



122

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 149

Шивээговь сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Сумын 1 дүгээр багийн иргэн Аззаяагийн Ялалт нь 2021 онд цусны хорт хавдар өвчин оношлогдож, байнгын асаргаанд сар бүр эмчлүүлж байгаа тул нэг удаагийн эмчилгээний зардалд 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид зарцуулагдах 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг хууль журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ



42123 150